

Үндэсний Зохицуулах Зөвлөл ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслийн хэрэгжилттэй ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн ТСА, ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо (МСЭМХ), Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо (МӨАУМХ), Хүүхэд өсвөр үеийг ивээх төв зэрэг байгууллагуудтай танилцсан ажлын тайлан

Зорилго: ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн ТСА, ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА, Монголын сумын эмч мэргэжилтний холбоо (МСЭМХ), Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо (МӨАУМХ), Хүүхэд өсвөр үеийг ивээх төв зэрэг байгууллагуудын Глобал сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах, зөвлөмж гаргах, тулгарч буй саад бэрхшээлүүдэд дэмжлэг үзүүлэх.

Хугацаа: 2018 оны 11 дүгээр сарын 20

НЭГДҮГЭЭР БАГ

Хамрагдсан газрууд:

- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн ТСА,
- ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА,
- Монголын сумын эмч мэргэжилтний холбоо (МСЭМХ)

Ажилласан бүрэлдэхүүн:

1. А.Цэцэгмаа, ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн
2. Ц.Даваасүрэн, ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн
3. Г.Нямпүрэв, ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн
4. Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч

“ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн ТСА”

Уулзсан хүмүүс:

1. Д.Энхмандах, СТСА-ны дарга
2. Д.Ганцэцэг, СТСА-ны эмч
3. н.Дорждэрэм, СТСА-ны эмч

Ерөнхий байдал:

ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны алба нь нийт 46 эмч ажилтантай ба 2003 оноос хойш Глобаль Сангийн салбар хүлээн авагч байгууллагаар тогтвортой ажиллаж ирсэн. Сүрьеэгийн бүртгэгдсэн шинэ тохиолдол 2015 онтой харьцуулахад 4270-аас 2759 тохиолдол болж буурсан нь нэг талын амжилт мэй харагдаж байгаа боловч улсын хэмжээд оношилгооны чадамжийг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Үүний дагуу 2018-2020 онд хэрэгжих ГС-гийн шинэ төслийн хүрээнд нийт 10 зөөврийн дижитал рентген (Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий, ХӨСҮТ) 4 жене эксперт аппаратыг (Баянхонгор, Сэлэнгэ, Төв, Орхон) шинээр ханган нийлүүлж улмаар улсын хэмжээнд нийт 15 дижитал рентген, 20 жене эксперттэй болж оношилооны чадвар сайжрах хандлагыг харуулж байна. 2017 оны байдлаар сүрьеэгийн эмчилгээний явцад хяналт алдалт улсын хэмжээнд 10%-аас бага ч Энэрэл эмнэлэгийн хувьд 50%-тай гарсан байна. Сүрьеэгийн эмийн ханган нийлүүлэлтийн хувьд Нэг болон цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмийн 10%, Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмийн 80%-ийн Глобаль Сангийн санхүүжилтээр нийлүүлж байна. Хүний нөөцийн хангалт 40%-аар дутагдаж байгаа энэ үед төслийн хүрээнд сүрьеэгийн эмч бэлтгэх үйл ажиллагааны хүрээнд 18 эмчийг сургах сургалт өнгөрөгч сард эхэлсэн байна. Үүнд: Дорноговь-3, Дорнод, Дундговь, Сэлэнгэ-2, Төв, Улаанбаатар-7, Ховд, Архангай, Хэнтий зэрэг аймгуудаас хамрагдсан байна. 2019-2020 оны хооронд мөн дахин 18 сүрьеэгийн эмч бэлтгэхээр төлөвлөж байна.

САНХҮҮ: Санхүүгийн хүсэлтийг боловсруулаад санхүүжилтээ хүлээн авах хүртэл маш олон шат дамжлагийг дамждаг тул хугацаанд нь хүлээн авч чаддаггүй . Тухайлбал үйл ажиллагааны 2-р улирлын санхүүжилт энэ оны 6-р сарын 29-нд ГС-гаас шилжин орж ирсэн боловч бараг 3 сарын дараа буюу 9-р сарын 12-нд төсвийг зарцуулах зөвшөөрөл бүхий эрх Сангийн яамны төрийн санд нээгдсэн. Улмаар дараа дараагийн улирлын төлөвлөгөөт үйл ажиллагаа хоцорч байна. Орон тооны санхүүч, нягтлан ажилладаггүй нь мэргэжлийн бус эмч мэргэжилтэн хуваарьт ажлын хажуугаар санхүүгийн тайлан тооцоо гаргах шаардлагатай болдог нь ажлын ачааллыг маш их нэмэгдүүлдэг байна. 2018 онд нийт 2,470,711 ам.доллар бүхий санхүүжилт батлагдсанаас ихэнх хувь нь тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт байна. Үүнээс одоогийн байдлаар 143,711 ам.долларын үлдэгдэлтэй байна. Энэ оныг дуустал үйл ажиллагаануудаа шахаж гүйцэтгээд илүү гарах зардлыг дараа жилрүү шилжүүлэх хүсэлтийг төслийн ХЗН-д өргөн барьсан.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Ханган нийлүүлэгдсэн эм, лабораторийн урвалжийг хүлээн авахын тулд гаалийн бүрдүүлэлт хийдэг ба энэ нь маш их шат дамжлагатай тул дор хаяж нэг сар болж ГЕГ-т хүрдэг. ЭМЯ-тай хамтын ажиллагаа удаашралтай, үл ойлголцсон байдалтай байдаг ба албан бичгүүдэд цаг тухайд нь хариу өгдөггүй. Энэ оны 4-р сард МУ-д тээвэрлэгдэн орж ирсэн 20 нэр төрлийн 2тн эм урвалж бодисийг одоо хүртэл авч чадаагүйгээс гаалийн агуулах, Эм Импекс компанийн агуулахад нэмэлт төлбөр төлж үргүй зардал гаргаж байна. Мөн эмийн хомсдол үүсч өвчтнүүдийн эмийг таслахгүйн тулд “Эм импекс” компанийн агуулахаас тусгай зөвшөөрөлгүйгээр (ЭМ-ийн сайдын тушаал) ханган нийлүүлэгдсэн эмийг хүлээн авч өвчтнүүдэд өгч байгаа ноцтой бэрхшээл тулгарч байна. Төслийн хүрээнд ханган нийлүүлэгдсэн үзлэгийн тоног төхөөрөмжүүд болох зөөврийн рентген, жене эксперт аппарат энэ оны 4-р сард МУ-ын гаалид тээвэрлэгдэн ирсэн боловч өнгөрөгч 9-р сард ХӨСҮТ хүлээн авч, 10 сард сургалт хийж, 11 сард хувиарлагдан тараагдсан зэргээс ЕБС-дад эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах ажил зэрэг төлөвлөгөөт үйл ажиллагаанууд хийгдэхгүй хоцорч байна.

Дүгнэлт: Төслийн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хийгдэх боломжоор хангуулах тэр дундаа Үндсэн хүлээн авагч байгууллага асуудлыг дор нь шийдвэрлэж, албан бичгүүдэд цаг тухайд нь хариу өгч, дэмжиж ажиллах шаардлагатай байна. Мөн ханган нийлүүлэлт ялангуяа эмийн тооцоолол, санхүүгийн тайлан болон төслийн холбогдох бусад асуудлаар ХЗН-ийн мэргэжилтэнгүүд ажлын байран дээр арга зүйн дэмжлэг үзүүлж байх шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 2018 оны 1-р улирлын хувьд нийт 6 үйл ажиллагаа төлөвлөгдсөнөөс 5 үйл ажиллагаа 100%-ийн биелэлттэй, ЕБС-дад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах үйл ажиллагаа 56.6% байна (дээр дурдсан шалтгааны улмаас тус үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүй байна). Нийт гүйцэтгэл 83.3%.

2018 оны 2-р улиралд Лаборант нарыг сүрьеэг оношлох түрхцийн шинжилгээний аргад сургах сургалт, Сүрьеэг оношлох молекул биологийн Gene Xpert шинжилгээ сургалт, ОЭТС-ийн богино хугацааны эмчилгээг нэвтрүүлэх, эмнэлзүйн ур чадварыг сайжруулах сувилагч нарын сургалт, Сүрьеэгийн өнөөгийн байдал ба эм зүйчдийн оролцоо сэдэвт сургалт, Сүрьеэгийн бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах, цахим бүртгэлийн системийн ашиглалтын талаар ажлын байрны сургалт зохион байгуулах, дэмжлэгт хяналт хийх, Эх хүүхдийн ЭМ, ДОХ, БЗДХ, Сүрьеэгийн

хөтөлбөрүүдийн хамтын ажиллагааг сайжруулах уулзалт, бүх түвшинд сүрьеэ, ДОХ-ын хавсарсан халдварын хөтөлбөрийн хамтын ажиллагааг сайжруулах, Улаанбаатар, Төв, Дархан аймгуудад дэмжлэгт хяналт хийх гэх мэт төлөвлөгөөт үйл ажиллагаануудыг 100% хийж гүйцэтгэсэн боловч ЕБС-дад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгээгүй болно. Нийт гүйцэтгэл 91% байна.

2018 оны 3-р улирлын хувьд нийт 13 ажил төлөвлөснөөс Сүрьеэгийн бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах, цахим бүртгэлийн системийн ашиглалтын талаар ажлын байрны сургалт зохион байгуулах, дэмжлэгт хяналт хийх, Эх барих эмэгтэйчүүдийн сүрьеэгийн оношилгооны эмнэлзүйн ур чадварыг сайжруулах сургалт, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнийг цогц тусламж үйлчилгээнд тэдний үүрэг хариуцлагыг сайжруулах сэдэвт сургалт зэрэг үйл ажиллагаануудыг ирэх сард багтаан хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Бусад 10 үйл ажиллагааг 100% хийж гүйцэтгэсэн ба нийт 77%-ийн хэрэгжилттэй байна.

2018 оны 4-р улиралд Сүрьеэгийн эмийг гадаад чанарын хяналтын шинжилгээнд хамруулах, Сүрьеэгийн үндсэн мэргэжлийн эмч бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулах, ХӨСҮТ-ийн СТСА-д бичиг хэрэг, холбооны зардал, Сүрьеэгийн нэгжүүдийн агаар шүүгчийг солих, агааржуулалт, салхивчийн инженер бэлтгэх сургалтанд хамрагдах замын зардал, Сүрьеэгийн үндэсний лавлагаа лабораторийн гадаад чанарын хяналт зэрэг үйл ажиллагаануудыг хийхээр төлөвлөсөн байна.

Эмийн агуулах засварлах ажил хойшилсон, одоогоор тендер зарлагдсан байгаа.

ХӨСҮТ-ийн 3 рентген аппарат байсны 2 нь эвдэрсэн, 1 нь БНСУ-аас ханган нийлүүлэгдсэн рентген дахин ашиглагдахгүй болсон, 2 дах нь Герман улсаас ханган нийлүүлэгдсэн суурин рентгенийг засуулах ажлыг хөөцөлдөж байгаа. Сая 11 сард нийлүүлэгдсэн 2 зөөврийн рентгенийг даатгуулах ажил хийгдэж байна. Орон нутагт тарагдсан зөөврийн рентген аппаратыг даатгуулах талаар зөвлөж байгаа.

САНАЛ: Төслийн хүрээнд ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийн насжилтыг нэмэгдүүлэхийн тулд тусгай бэлтгэгдсэн инженерийг байнга ажиллуулах шаардлагатай. Мөн цалин урамшуулалтай санхүүгийн мэргэжлийн хүн ажиллуулах хэрэгцээ байна.



ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Үндэсний болон орон нутгийн түвшинд оношлогооны чадавхи сайжирсан. (Зөөврийн рентген аппарат-15, ХӨСҮТ-2, Жене-эксперт аппарат 14+6)
- Идэвхтэй илрүүлэлт хийх чадавх бүрдсэн.
- ЭТС-ийн эмчилгээний хамралт нэмэгдсэн
- ЭТС-ийн эм, оношлуурыг тасралтгүй ханган нийлүүлж байна.
- ОЭТС-ийн богино хугацааны эмчилгээг нэвтрүүлэх боломж бүрдсэн. Одоогоор 16 өвчтөн эмчилгээ хийлгэж байна.
- Ажлын байрны халдварын сэргийлэлт хяналт сайжирсан.
- Суурь судалгаа, үнэлгээ хийгдэж, нотолгоонд тулгуурласан бодлого хөтөлбөрийг боловсруулах нөхцөл бүрдсэн.
- Эмч мэргэжилтний чадваржуулсан, мэргэжил арга зүйгээр хангасан. Богино хугацааны мэргэжил олгох 9 сарын сүрьеэгийн эмчийн сургалтыг хөтөлбөр гаргаж, сургалт эхлээд байна. (Эмч 18)
- Сүрьеэгийн цахим тандалтын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна.
- Чиглэл бүрээр сургалтууд амжилттай зохион байгуулж байна. (Эх барих эмэгтэйчүүд, сүрьеэ, эм зүйч гэх мэт)
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжсөн.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:

- Санхүүгийн үйл ажиллагаа, тайлан тооцоог эмч нар гаргаж байна. Санхүүгийн мэргэжлийн хүн ажиллуулах, цалин урамшуулал олгох
- Төрийн санд эрх нээлгэх, ЭМЯ-наас ХӨСҮТ-ийн дансанд мөнгө шилжүүлэх үйл явц удаашралтай байна.
- Глобаль сангийн санхүүжилтээр авдаг эмүүдийн гаалийн бүрдүүлэлт татвараас чөлөөлүүлэх хүсэлт удаашралтай.
- Захиалсан эмүүд хугацаандаа ачигддаггүй. Тухайлбал:
 - ЭМЯ-наас эм болон бусад бараа бүтээгдэхүүнийг сайдын тушаалаар хуваарилдаг болсноос хойш эм болон урвалж бусад зүйлийг гаалиас авахад хүндрэлтэй.
 - Өнгөрсөн 10 сард ирсэн эм одоо хүртэл хуваарилагдаагүй, тушаал гараагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохих ажилтнуудыг сард тодорхой хоногоор ажиллуулж, тусламж, дэмжлэг авах, эм урвалжийн тооцоо гаргах ажилд ХӨСҮТ-ийн эмийн мэргэжилтэнд дэмжлэг үзүүлэн үнэн зөв гаргахад туслах;
2. Санхүүгийн тайлан, тооцоо хийж байгаа нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудад нэмэгдэл цалин/урамшуулал олгох асуудлыг судлах/;
3. Үйл ажиллагааны тайлангаа, санхүүгийн бүртгэлтэйгаа уялдуулах /хэдий хэмжээний хөрөнгө ашиглахаар төлөвлөснөөс, тухайн цаг үед хэдийг ашиглаж, хэдийн үлдэгдэлтэй байгаа, үлдэшдэл хөрөнгийг санхүүгийн жил дотроо бүрэн ашиглах эсэх талаархи төлөвлөгөө г.м./- *дээрх зөвлөмжүүдийг дараагийн байгууллагуудад мөн адил өгч байна.*
4. Эмийн агуулах засварлах ажлын явцыг тогтмол мэдээлж байх;
5. Үндсэн хүлээн авагч байгууллага хэрэгжиж буй үйл ажиллагааг цаг хугацаандаа явуулахад дэмжлэг үзүүлэн тушаал шийдвэрийг гаргаж асуудлыг шийдвэрлэж байх;
6. ҮХА сангийн яам болон бусад холбогдох байгууллагуудад эм урвалж болон бусад ханган нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийг хугацаанд нь холбогдох байгууллагуудад нийлүүлэхэд анхаарч шаардлага бичиг хүргүүлэн хугацаа алдахгүй байх тал дээр анхаарч ажиллах;

7. Ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байгаад хяналт тавин ажиллах.

“ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА”

Уулзсан хүмүүс:

1. Х.Даваажав, БЗДХ-ын ТСА-ны зөвлөх эмч
2. Б.Оюунбилэг, БЗДХ-ын ТСА-ны эмч
3. М.Тунгалаг, БЗДХ-ын ТҮ тасгийн эрхлэгч
4. П.Түмэндэмбэрэл, БЗДХ-ын ТСА-ны эмч

Ерөнхий байдал:

ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА нь Глобал Сангийн төсөл хөтөлбөрийг 2003 оноос хойш хэрэгжүүлсэн бөгөөд үйл ажиллагаа нь тогтворжсон, ХДХВ-ийн нийт халдварыг бага хэмжээнд тогтоон барих үйл ажиллагаанд ТББ-уудтай хамтран нягт ажиллаж байна. БЗДХ болон ХДХВ/ДОХ гэсэн хоёр тасагтай нийт 30 гаруй эмч мэргэжилтэнтэй. Хөдөө орон нутгуудын Нэгдсэн эмнэлэгт БЗДКабинет ажиллаж байна. Өвчлөлийн байдлыг авч үзвэл БЗДХ-ын хувьд 2017 оны байдлаар нийт 15360 зонхилон тохиолдох өвчин (тэмбүү, зөг хүйтэн, трихомониаз) бүртгэгдсэн ба энэ нь нийт халдварт өвчний 34,7%-ийг эзэлж байна. Жилд нийт 22000 орчим БЗДХ бүртгэгддэг байна. Төрөлхийн тэмбүүгийн өвчлөл нэмэгдэж байна. Жирэмсний хяналт хангалтгүй муу байна. ХДХВ-ийн хувьд 2018 оны байдлаар нийт 266 тохиолдол бүртгэгдсэнээс энэ онд 17 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Тандалт судалгаагаар нийт 598 ХДХВ-ийн тохиолдол байх тооцоолол гарсанаас 35%-ийг нь илрүүлсэн ба үүний 89%-ийг нь эмчилгээнд хамруулсан, үлдсэн 60%-ийг илрүүлээгүй байна. Илрүүлгийг нэмэгдүүлэхийн тулд эрсдэлт бүлгийн хүн амтай ажилладаг ТББ-уудтай хамтран ажилладаг. Сүүлийн жилүүдэд бисекс буюу өөрөөсөө эсрэг болон ижил хүйсийн хүнд татагддаг 50-аас дээш насны хүн ам нийт халдварыг тарааж байна.

САНХҮҮ: Санхүүгийн хүсэлтийг боловсруулаад байгууллагын даргаас Төрийн сан хүртэл маш их шат дамждаг нь цаг хугацаандаа санхүүжилтээ хүлээн авахад бэрхшээлтэй байдаг. Санхүүгийн энэ асуудал байнгын тулгарсаар байна. Нэгдсэн лабораторийн албаны санхүүжилт тус албаны санхүүжилттэй хамт хийгддэг нь эмх замбараагүй байдал үүсгэдэг. Санхүүжилтийг хугацаандаа хүлээн аваагүйгээс болж төлөвлөгөөт үйл ажиллагаа хоцордог.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Төслийн нийт санхүүжилт өмнөх оноос 40% багассан тл ханган нийлүүлэлт мөн дагаад багассан. Олон улсын чиг ханлагаас авч үзвэл ХДХВ-ийн эсрэг эмчилгээнээс илүү урьдчилан сэргийлэх тэр дундаа бэлгэвчийн хэрэглээг нэмэгдүүлэхийг зөвлөж байгаа. Гэвч төслийн санхүүжилт багассанаас улбааалан бэлгэвчийн захиалга буурсан.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Улсын хэмжээнд хүний нөөц дутагдалтай байдаг, 3 аймаг кабинетийн эмчгүй байсан. Төслийн хүрээнд 15 эмчийг 6 сарын хугацаанд тэтгэлэгтэй сургах үйл ажиллагаа өнгөрөгч сард эхэлсэн. Нийт 12 аймаг, 1 дүүргээс эмч сургаж байгаа. Үүнд: Дорноговь, Өмнөговь, Дундговь, Увс, Баян-Өлгий зэрэг аймгууд багтаж байна.

Өнгөрөгч онд төслийн хүрээнд ХӨСҮТ-д 200-гаад сая төгрөг бүхий санхүүжилтээр Хөнгөвчлөх тасаг нээсэн. Нийт 4 ортой, 2 эмч 3 сувилагчтай ажиллаж байна. Төслийн 1-2-р улирлын төлөвлөсөн 11 үйл ажиллагаанаас 10 үйл ажиллагаа хийгдсэн, 1 ажил хийгдэж байгаа.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Эхээс урагт ХДХВ-ийн халдвар дамжаагүй амжилттай. Нийт 17 эхээс 24 хүүхэд төрсөн. 2017 оноос өмнө халдвартай жирэмсэн эх ХӨСҮТ-д төрдөг байсан нь ялгаварлан гадуурхагддаг байсан бол 2017 оноос хойш төрөх эмнэлэгүүдийн эмч мэргэжилтнүүдэд олон удаагийн сургалт зохион байгуулсанаар тэдгээр эх харьяа төрөх эмнэлэгүүдэд төрж байна. Үүнийг дагаад халдвар хамгаалал сайжирсан.

Глобаль Сангийн төсөл МУ-д хэрэгжсэнээр нийт 12000 хүнийг ХДХВ-ийн халдвараас хамгаалж чадсан судалгааг хөндлөнгийн зөвлөх хийсэн байдаг.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ: Санхүүжилт хүлээн авах үйл явцыг түргэсгэх.

- Төслийн 2018 оны 3-4-р улирлын санхүүжилт орж ирээгүй сангийн яаманд эрх нээгдээгүй тул үйл ажиллагаа хийгдэхгүй хойшилж байна. ЭМЯ дээр хугацаа алддаг. Санхүүжилт хүлээн авах үйл явцыг түргэсгэх.
- Эмч мэргэжилтэн хангалтгүй, дутагдалтай.

ЗӨВЛӨМЖ:

- ҮХА санхүүжилт хойшилж хугацаа алдаж үйл ажиллагаа хугацаандаа хэрэгжихгүй байгаа тал дээр анхаарч санхүүжилтийн асуудлыг хурдан шийдэхэд анхаарах;

- ХЗН санхүүжилт хугацаандаа шийдэгдэхгүй байгаа дээр анхаарч ямар арга хэмжээ авч байгаа талаар танилцуулж ямар дэмжлэг хэрэгтэй байгааг хугацаа алдалгүй ҮЗЗ-д мэдээлж байх.



“Монголын сумын эмч мэргэжилтний холбоо (МСЭМХ)”

Уулзсан хүмүүс:

1. Ц.Даваахүү-МСЭМХ-ны гүйцэтгэх захирал (аймаг хоорондын сорьц тээвэрлэлтийг хариуцдаг)
2. н.Чимиддолгор-МСЭМХ-ны эмч (сумдаас аймагруу сорьц тээвэрлэлтийг хариуцдаг)

Ерөнхий байдал:

МСЭМХ нь 2012 онд үүсгэн байгуулагдсан, 21 аймагт салбар зөвлөлтэй, Глобал Сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн салбар хүлээн авагч байгууллагаар 2016 оны 10-р сараас эхлэн ажиллаж байгаа.

Хөтөлбөрийн нэр: “Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж, хэвшүүлэх, эмийн дасалтай сүрьеэгийн аюулд анхаарал хандуулж ажиллах”

Ажиллаж буй бүрэлдэхүүн:

- хөтөлбөрийн зохицуулагч-1,
- сорьц хариуцсан эмч-2,
- нягтлан бодогч-1,
- /холбооны УЗ, ХЗ, салбар зөвлөл/

Зорилго:

Сорьц тээвэрлэх тогтолцоог төлөвшүүлэх, бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах;

Зорилт:

Аймаг, сумдын түвшинд цэрний сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг төлөвшүүлэх замаар уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх улмаар эмэнд тэсвэртэй сүрьеэгээс сэргийлэх.

Үйл ажиллагааны чиглэл:

1. Сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, тогтвортой байдлыг хангах;
2. Нөлөөллийн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах, орон нутгийн шийдвэр гаргагч, хамтрагч байгууллагуудын оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх;
3. Сумын эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн тусламж үйлчилгээ, сорьц тээвэрлэх үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, ажлын байрны сургалт явуулах;
4. Алслагдсан орон нутгийн болон зорилтот хүн амын эрүүл мэндийн идэвхитэй илрүүлэг үзлэг зохион байгуулах;

САНХҮҮ: 2016 оны 10-р сараас 2018 оны 6-р сарын 30 хүртэл санхүүжилт:


2016 оны 4-р улирал санхүүжилт: 71,884,590 төгрөг бүхий төлөвлөлттэй байсанаас 10,100,730 төгрөгийн үлдэгдэлтэй; 2017 оны нийт санхүүжилт 379,337,960 төгрөг байснаас үлдэгдэлгүй; 2018 оны эхний хагас жилийн санхүүжилт нийт 136,856,561 төгрөг байснаас 10,753 төгрөгийн үлдэгдэлтэй.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Шинэ төслийн хүрээнд зөөврийн компьютер төлөвлөгдсөн ч Үндсэн хүлээн авагч байгууллага олгохоос татгалзсан. Төслийн

хүрээнд бүх аймаг сумдад сорьц хадгалах хөргөгч, зөөврийн сав, сорьц тээвэрлэх зардал, сорьц тээвэрлэж буй хүнд урамшуулал олгох зэргийг олгодог.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Тухайн аймагт сонгогдсон, бэлтгэгдсэн хүн сорьцыг тээвэрлэдэг. Сорьц тээвэрлэх зардлыг тооцож олгодог. Сумаас аймаг руу сорьц зөөвөрлөсөн тохиолдолд сумын ЭМТ-рүү, аймгаас төврүү сорьц зөөвөрлөсөн тохиолдолд замын зардал, урамшууллыг аймгийн ЭМГ-руу шилжүүлэн ажилладаг. Алслагдсан орон нутгийн зорилтот бүлгийн хүн амын дунд идэвхтэй илрүүлгийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Ховд, Төв аймгийн сумдад зохион байгуулсан. ЭМЯ-ны 2018 оны А 126-р үзлэг зохион байгуулах тухай тушаал гарсантай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй зогссон. 43 суманд түрхэцийн шинжилгээ хийж байгаа, лабораторийн тоног төхөөрөмжөөр хангасан.

Орон нутгийн сорьц тээвэрлэлт:



2016.10-2018.09 сарын байдлаар орон нутгаас 5407 удаагийн давтамжтай сорьц тээвэрлэж, нийт 12740 хүний 25480 сорьцийг авч, шинжилгээнд хамруулж, нийт 680 сүрьеэгийн шинэ тохиолдлыг илрүүлж, эмчилгээнд хамруулсан. Оношилгооны зорилгоор тээвэрлэсэн сорьцын эерэг илрэлтийн чанарын үзүүлэлтийн дундаж 7,5%-

тай байна. 2017 тайлангийн жилд шинээр илэрсэн уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн 18,3%-ийг нь сорьц тээвэрлэж илрүүлсэн.

Нөлөөллийн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах, орон нутгийн шийдвэр гаргагч, хамтрагч байгууллагуудын оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд Сүрьеэ өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажилд анхан шатны шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх; тэднийг мэдээллээр ханган мэдлэг, хандлагыг сайжруулах; ажлын уялдаа холбоог нэмэгдүүлэх; сүрьеэгийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх, хянах ажлыг цогц байдлаар хүргэхэд дэмжлэг үзүүлэх; сорьц тээвэрлэлтийг орон нутагт төлөвшүүлэх, тогтвортой байдлыг хангах, сүрьеэг эрт илрүүлэх.

ЗӨВЛӨМЖ:

- Алслагдсан хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах ажлыг хэрхэн зохион байгуулах тал дээр ҮХА болон ХЗН асуудлыг ямар байдлаар шийдвэрлэх боломжтой байгаа саналыг ҮЗЗ-д эргэн мэдээлэх.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ: Сорьц тээвэрлэгч нарын урамшуулал, замын зардлыг өмнө нь хүн тус бүрийн дансруу шилжүүлдэг байсан боловч өнгөрөгч 4 сараас төрийн сантай нэгтгэж сумын ЭМ-ийн төврүү шилжүүлдэг болсон. Ингэхдээ маш их дамжлага дамжиж тухайн зардал маш их цаг алдаж хүндээ хүрдэг нь үйл ажиллагааны эрчийг сулруулж байна.



ХОЁРДУГААР БАГ

Хамрагдсан газрууд:

- Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо /МӨАУМХ/
- Монголын Хүүхэд өсвөр үеийг ивээх төв

Ажилласан бүрэлдэхүүн:

1. Р.Оюунгэрэл, ҮЗЗ-ийн гишүүн
2. Б.Баярмаа, ҮЗЗ-ийн гишүүн
3. С.Энхжин, ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн
4. Л.Номин-Эрдэнэ, ҮЗЗ-ийн ажлын албаны ажилтан

Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо

/МӨАУМХолбоо/

Уулзсан хүмүүс:

1. Ш.Хажидмаа, Хөтөлбөр хариуцсан гүйцэтгэх захирал

Ерөнхий байдал

Байгууллагын хүний нөөц

- ❖ Ерөнхийлөгч- Төслийн ахлагч
- ❖ Гүйцэтгэх захирал-Хяналт үнэлгээний мэргэжилтэн
- ❖ Нягтлан бодогч
- ❖ Төслийн ажилтан
- ❖ Оффиссын ажилтан

29 салбар зөвлөлийн дарга 225 ӨЭМТ, 3000 гаран эмч, мэргэжилтнүүд сайн дураар эвлэлдэн нэгдэж холбооны үйл ажиллагаанд хамтран оролцдог. ӨЭМТ-н ЭМТ хуулийн 26.2-т зааснаар “Төрөөс үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хувийн хэвшлийн байгууллага” ӨЭМТ-ийн дүрмийн дагуу нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдаж нөхөрлөлийн хуулиар үйл ажиллагаа зохицуулагддаг.

ГС-ийн дэмжлэгтэй төслийн хүрээнд ӨЭМТ-үүдэд сүрьеэгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэн, диспансерийн ачаалалыг бууруулан, тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулан, чирэгдлийг багасгах, илрүүлэлтийг нэмэгдүүлэн өвчлөл тархалтыг бууруулах зорилго тавин ажиллаж байна.

Аймаг, Дүүргийн ЗДТГ, ЭМГ, НЭ, ЭМТ, диспансер, баг, хорооны засаг дарга, ӨЭМТ төрийн болон ТББ хамтран сүрьеэгийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал шийдвэрлэх арга замын талаар 2 жил тутам нийт 54 удаагийн зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж тодорхой асуудлуудыг шийдвэрлэх талаар зөвлөмж гарган хэрэгжүүлж ирсэн нь үр дүнтэй байгаа бөгөөд Аймаг, дүүргүүдийн шийдвэр гаргагчдын идэвхи оролцоо сайжирч дэмжлэг үзүүлэх байдал нэмэгдсэн.



ГС-ын дэмжлэгтэй 2018-2020 оны төслийн шалгуур үзүүлэлт

- Тайлант хугацаанд илэрсэн сүрьеэгийн нийт тохиолдлоос (бүх хэлбэр) ТХХТ-н (өрхийн эмнэлэг ба хувийн эмнэлэг) хүрээнд илгээсэн ба оношилсон тохиолдлын (бүх хэлбэр) тоо, хувь
- Өрхийн эмнэлгийн үзүүлж буй ДОТС-ын тусламж үйлчилгээнд (үндэсний бодлогын дагуу) хамрагдсан нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн тохиолдлуудын амжилттай эмчлэгдсэн (эдгэрсэн болон эмчилгээ дуусгасан) өвчтөний тоо, хувь

САНХҮҮ: 2018 оны 1-р улирлын санхүүжилт хоцорч 3 дугаар сарын 27-нд орж ирсэнээс үүдэн үйл ажиллагаа удаашран тайлант хугацаанд товлосон үйл ажиллагаа ихээхэн хоцорч саад бэрхшээл учирсан. Түүнээс хойш үйл ажиллагаагаа жигдлээд явж байна.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ:

2008 онд төсөл эхлэхэд \$5600-г Зөөврийн компьютер, проектор, зургийн аппарат зэргээр хангасан.

2010 онд \$9600 нөхөн хангалт хийсэн. Үүгээр:

136 ӨЭМТ-ийг хөргөгч, сорьц тээвэрлэх саваар хангасан.

46 ӨЭМТ-д ус буцалгагч авч өгсөн.

144 ӨЭМТ-д ДОТС самбар хийж өгсөн.

2013 онд Зөөврийн компьютер-\$3000, гар утас-\$120 Машин-\$40000 нийт \$43120 хангамж хүртсэн.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 2018-2020 оны төслийн хүрээнд Сүрьеэгийн эрт илрүүлэлтийг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах өвчтөн төвтэй нэгдсэн халамж, цогц урьдчилсан сэргийлэлтийг бүрдүүлж, эмийн тэсвэртэй сүрьеэд анхаарал хандуулах зорилгын хүрээнд ӨЭМТ бүрээс 1 их эмч, 1 сувилагчийг сургалтанд хамруулж, Сургагч багшаар бэлтгэн гэрчилгээ олгосон. Тухайн сургагч багш нар ӨЭМТ дээр сүрьеэгийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулж ажилладаг. 2017 оны байдлаар нийт 78 удаагийн сургалтаар 1866 өрхийн эмч, 1142 өрхийн сувилагч, 151 нийгмийн ажилтан, 232 ӨЭМТ-ийн дарга, 384 сургагч багш нарыг бэлтгэх чадавхижуулах сургалтанд хамруулснаас гадна шинэ залуу 393 эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах давтан сургалтанд хамруулсан. Сургалтын гарын авлага, сурах бичиг, ном гаргасан. ӨЭМТ дээр дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд

- Өрхийн эмч нар үзлэг хийх явцдаа сэжиглэн диспансерт илгээх, эсвэл сорьц авч зөөх
- диспансерт онош тодруулахаар цэр авч илгээх
- Өрхийн эмч сэжигтэй тохиолдлыг бүртгэх
- Сэжигтэй тохиолдлоос /илгээсэн, цэр зөөсөн/ сүрьеэ илэрсэн эсэхийг диспансерийн эмчтэй тулгах, бүртгэх
- Хавьтлыг эрт илрүүлгийн үзлэгт хамруулах
- ӨЭМТ-д эм уулгаж хяналтанд байлгах

ӨЭМТ-д сүрьеэгийн тусламж үйлчилгээг хэвшүүлэх зорилгоор аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч, аймаг дүүргийн салбар зөвлөлийн дарга нартай хамтран ӨЭМТ-үүдэд төлөвлөгөөний дагуу дэмжлэгт хяналт шинжилгээ үнэлгээ хийж хэвшсэн.

2008-2017 онд Нийслэлийн 8 дүүрэг, 7 аймгийн 168 ӨЭМТ-д 111 удаагийн явалтаар давхардсан тоогоор 772 ӨЭМТ-д дэмжлэгт хяналт, үнэлгээг аймаг дүүргийн диспансерийн зохицуулагч эмч, СЗД-тай хамтран ӨЭМТ-ийн Сүрьеэгийн тусламж үйлчилгээний байдалтай танилцан заавар зөвлөгөө өгч ажилласны үр дүнд үйл ажиллагаа хэвшиж байна. Хяналт үнэлгээний дараа аймаг, дүүргийн ЗДТГ, ЭМТ, диспансер, ӨЭМТ-ийн дарга, эмч нарыг оролцуулан тайлангийн хурал зохион байгуулж, амжилт ололтыг дүгнэн, тулгамдсан асуудлыг ярилцан шийдвэрлэдэг нь үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлэхэд ихээхэн дэм болдог.

Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн ЗД, ЗДТГ, Хорооны засаг дарга нар, БХ, ХХХ, ЕБС-ийн захирал, ӨЭМТ дарга нар 455 төлөөлөл оролцсон Сүрьеэгийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам агуулгатай хэлэлцүүлгийг хийж бүлгээр ажиллан бодлогын баримт бичиг /зөвлөмж, дэд хөтөлбөр боловсруулан/ гарган үндсэн чиглэлд тусгахаар шийдвэрлэж байна.

Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдийн 125 ӨЭМТ-ийн 224 сүрьеэгийн зохицуулагч нарыг ХӨСҮТ-ийн СТСА эмч нартай хамтран чадавхижуулах сургалтанд хамруулан 1 багц цагийн гэрчилгээ олгон, гэрээ байгуулан ажиллаж байна. Зохицуулагч нар нь ӨЭМТ-ийн сүрьеэгийн тусламж үйлчилгээг гардан зохион байгуулдаг.

21 аймгийн ЗД, ЗДТГ, багийн засаг дарга нар, ХХХ, БХ, ОБ, ЕБС, МСҮТ, ӨЭМТ-ийн дарга нар, ЭМГ, НЭ дарга мэргэжилтнүүд нийт 781 төлөөлөл оролцсон Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд олон талын оролцоог хангах, өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам илтгэл мэдээлэл сонсон бүлгээр ажиллан хэлэлцэж бодлогын бичиг баримт зөвлөмж гаргах, дэд хөтөлбөр боловсруулан үндсэн чиглэлд тусган ажиллаж байна.

Шинээр Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Сүхбаатар, Дундговь, Төв, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл 14 аймгийн 50 Өрхийн эрүүл мэндийн төвийн 387 эмч сувилагч нарт Сүрьеэ өвчний мэдлэг олгох сургалт, 100

эмч, сувилагч нарыг сүрьеэгийн тусламж үйлчилгээ хариуцан ажиллах зохицуулагчаар бэлтгэв. Аймаг орон нутгийн диспансер ӨЭМТ хамтран ажиллахаар гэрээ байгуулав.

Аймаг, дүүргийн сүрьеэгийн өвчлөл бүртгэгдсэн сургуулийн ахлах ангийн сурагчдад “Сүрьеэ өвчний мэдлэг” олгох өртөөлчилсөн сургалтыг 82 сургуулийн 16400 сурагчдад аймаг нийслэлийн салбар зөвлөлийн дарга нар, ХӨСҮТ-ийн СТСА, аймаг, дүүргүүдийн диспансерийн эмч нартай хамтран зохион байгуулав. Сургалтын дараа хүүхдүүдээс мэдлэг сорих асуулт, сорил авч дүгнэхэд 90 дээш үнэлгээ авч байв.

2018 үйл ажиллагааны хэрэгжилт

1. Удирдлага зохион байгуулалт: 21 аймаг, 8 дүүргийн 29 салбар зөвлөлийн дарга нараар дамжуулан 225 ӨЭМТ-ийн сүрьеэгийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.
2. Сүрьеэгүй аймаг, дүүрэг санаачлагыг өрнүүлэн 21 аймаг, 8 дүүргийн анхан болон дунд шатны удирдлагуудад нөлөөллийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан, өрхийн эмч мэргэжилтнүүдэд чадавхижуулах сургалт хийх, тухайн аймаг орон нутаг дүүргийн ЕБС, МСҮТ сүрьеэ өвчний мэдлэг олгох өртөөчилсөн сургалт зохион байгуулан ажиллаж байна.
3. ӨЭМТ-д үзүүлж буй сүрьеэгийн тусламж үйлчилгээг хэвшүүлэх дэмжлэгт хяналт үнэлгээг хийх
4. ӨЭМТ-д үзүүлж буй сүрьеэгийн тусламж үйлчилгээний тайлан мэдээ, үр дүнг нэгтгэх

Удирдамжинд заасны дагуу ӨЭМТ 5 төрлийн маягт хөтөлдөг. Үүнд:

- Сүрьеэгийн тохиолдлын хавьтлын хяналтын бүртгэл
- Уушигны эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл
- Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлж буй сүрьеэгийн тусламж үйлчилгээний нэгдсэн тайлан
- Сүрьеэтэй өвчтөнүүдийн эмчилгээ хяналтын карт
- Сорьц зөөвөрлөлтийн тайлан

ТӨСЛИЙН ҮР ДҮН:

Зорилтот бүлэгрүүгээ чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа. Өрхийн эрүүл мэндийн төвүүд төслийг хэрэгжүүлэх талаар анхааран ажиллаж Глобал сангийн төслийн ажлыг хэрэгжүүлэх эмч, сувилагч томилогдон ажиллаж байна.

2011-2018 оны байдлаар ӨЭМТөвүүд

- 168 ӨЭМТ–ийн эмч, мэргэжилтнүүдийг сүрьеэгийн ТҮ татан оруулснаар диспансерийн ачаалалыг бууруулж, СТҮ эмч, мэргэжилтнүүдийг тоо өсч, хүртээмж сайжирсан.
- Иргэдэд Сүрьеэгийн ТҮ ойртож, чирэгдлийг багасгасан.
- Уушигны эмгэгтэй 20809 хүнийг сэжиглэж, 20879 хүнийг сүрьеэгийн диспансерт илгээж, 2106 сорьцийг 1634 удаагийн давтамжтайгаар зөөвөрлөж 909 сүрьеэгийн шинэ тохиолдлыг илрүүлж, илрүүлэлт нэмэгдсэн. Хяналт сайжирсан.
- ӨЭМТ –ийн сүрьеэгийн сөрөг тохиолдлын 30 орчим хувийг эмчилгээнд хамруулж , эмчилгээний амжилт 84% байна.
- 2017 байдлаар аймаг дүүргийн түвшинд шинээр илэрсэн сүрьеэгийн 21,5%-ийг, Улсын хэмжээнд шинээр илэрсэн сүрьеэгийн 22%-ийг ӨЭМТ илрүүлсэн байна

ТАЙЛАН: Тайланг улирал бүр ХЗН-руу илгээдэг.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ: Төр засгаас дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, Нийгмийн даатгалын сангаас ӨЭМТ-ийн нэг иргэний санхүүжилтын хэмжээг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах шаардлага үүссэн байна.

САНАЛ:

1. Цаашид ӨЭМТ-үүдийн хүний нөөцийн асуудлыг тогтвортой байлгах бодлогын арга хэмжээ авахад анхаарах, учир нь жил бүр хүний нөөцийн 40% солигддог нь бидний ажлын үр дүнг бууруулахад хүргэдэг.
2. ӨЭМТ-үүдийн эмч, мэргэжилтнүүдийг үр дүнтэй ажиллуулахад хөшүүрэг шаардлагатай байгааг жишээгээр тайлбарласан.

3. ӨЭМТ болон диспансерийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор эмч нарыг чадавхжуулах давтан сургалтанд хамруулах
4. Хүн амд хийж байгаа сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх
5. Орон гэргүй, ажилгүй иргэдийг нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах
6. Цэрний сав гэх мэт дутагдалтай байгаа зүйлүүдээр хангах / байгууллагаас /

Зөвлөмж

- Цаашид төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулан, ТБ-уудтай ойлголцон хамтран ажиллах хэрэгтэй.
- Олон талт хамтын ажиллагааг сайжруулах,
- Нийгмийн бүхий л бүлгийнхэн тэр дундаа ЕБС-ийн, хорооны нийгмийн ажилтнуудыг сурган нийт ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.
- Түүнчлэн тэтгэвэрт гарсан эмч, мэргэжилтнүүд болон оюутнуудыг амралтынх нь үеэр идэвхижүүлэн дадлагажуулж, зохих хөшүүргийг өгч ажиллавал цаашид гарах үр дүн нэмэгдэх бололцоотой.

Хүүхэд өсвөр үеийг ивээх төв

Уулзсан хүмүүс:

1. О.Хулан, Хүүхэд өсвөр үеийг ивээх төвийн тэргүүн
2. Б.Мөнхцэцэг, ДОХ-ын хөтөлбөрийн зохицуулагч
3. Л.Жаргалсайхан, Хүүхэд хамгааллын ажилтан

Эдгээр орон тооны ажилтнуудаас гадна АШУҮИС, МУБИС-ийн Нийгмийн ажилтны ангиудын оюутнууд дадлагажин ажилладаг байна.

Ерөнхий байдал

Монголын хүүхэд өсвөр үеийг ивээх төв нь 2005 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах зорилгоор байгуулагдсан. Улмаар 2008 оноос Глобаль сангийн дэмжлэгтэй төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд

хөдөө орон нутаг болон, нийслэлийн хүүхэд залуусд сургалт сурталчилгаа хийж, бэлгийн эрүүл мэндийн боловсролын талаар ойлголт мэдээллийг өгдөг. Сургалтын явцад гарын авлага, ном, танилцуулга болон тухайн хүүхдүүдийн хөгжлийн онцлогот тохирсон хараагүй хүүхдийн ном, дүлий хүүхдүүдэд дохионы хэлээр тайлбарласан бичлэгтэй CD, оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд танилцуулга ном зэргийг тусгайлан бэлтгэж хүргэсээр байна.



САНХҮҮ: 2018 оны 1-р улирлын санхүүжилт хоцорсон. Санхүүжилт буурсантай холбоотойгоор бүтэн цагаар ажиллаж байсан нягтлан ажлаасаа гарсан бөгөөд түүний хийх ажлыг мэргэжлийн хүнээр хийлгэхэд санхүүгийн хүндрэл тулгарч байна. Санхүүжилтыг улирлаар хүлээн авдаг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Ажилчдын цалин бидний гар дээр ЭМЯ-ны дансаар орж ирдэг бөгөөд ном, сурах бичиг хэвлэх зардлууд ЭМЯ-наас сонгогдсон байгууллагуудруу шилждэг тул өөр ханган нийлүүлэлт байдаггүй.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: ГС-ийн төслийн хүрээнд 2013 оноос хойш нийт өсвөр үеийнхэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2018 онд 15 аймагт болон УБ-ын 3 дүүргийн ӨЭМТ, ЕБС, Хорооны нийгмийн ажилтнууд болон хэсгийн ахлагч нарыг сургалтанд хамруулсан. 116, 29, 55, 25, 70, 63-р сургуулиуд дээр Эрүүл мэндийн хичээлийг өөрсдийн хөтөлбөрийн дагуу орж, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулдаг.

ГС-ын дэмжлэгтэй 2018 оны үйл ажиллагааны хэрэгжилт

Хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй хүмүүст зориулсан CD, болон хэвлэмэл материалууд, танилцуулга, ном зэргийг боловсруулан тараадаг. Эдгээр бүтээлүүдийн хэвлэлийн эхийг боловсруулаад ХӨСҮТ-д өгч шалгуулан цөөн тоогоор хэвлэн хүүхдүүдэд уншуулж туршуулан саналыг нь авч нэмэлт сайжруулалтыг хийж, түүний дараа олон тоогоор хэвлэн улмаар ХӨСҮТ-д өгч 21 аймаг, 9 дүүргийн эмнэлгүүдээр тараалгаж хүртээмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнийг 12 сарын 1 буюу ДОХ-ын өдрөөс өмнө амжуулахаар төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн өсвөр насны хүүхдүүд бэлгийн боловсролын талаар эцэг, эхтэйгээ ярилцаж, зөвлөгөө авах хүсэл байдаг боловч хэрхэн яриаг эхлүүлэх талаар мэддэггүй энэ талаар эцэг эхчүүдийг идэвхижүүлэх арга байгаа эсэх талаар асуудаг тул эцэг эхчүүдэд зориулсан ном хэвлүүлэн түгээхээр ажиллаж байна.

ТӨСЛИЙН ҮР ДҮН:

Зорилтот бүлэгрүүгээ чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа. Үр дүнг тооцох боломж бололцоо сул боловч “Нүдээ нээ”, “Ид шидийн орон” гэх мэт сургалтыг хийсний дараа тухайн сургалтанд хамрагдсан хүмүүсээс бидэнтэй холбогдон сургалтанд ашигласан гарын авлага, материалиудыг авч ашиглан өөрийн орон нутагт сургалтыг бие даан зохион байгуулах хүсэлт гаргадаг.

ТАЙЛАН: Тайланг улирал бүр ХЗН-руу илгээдэг.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:

- Хэвлэх үйлдвэртэй гэрээг байгуулан ЭМЯ-аар дамжуулан санхүүжилтыг илгээх хүсэлт өгөхөд үл ойлголцол үүсэж, ЭМЯ-ны зүгээс шалгалтыг давтан хийж хэвлэх хугацааг удаашруулдаг. Ингэснээр бидний төлөвлөсөн үйл ажиллагаа удааширдаг.
- Төрийн байгууллагуудын мэргэжилтнүүд байнга солигддог нь ажлын явцад хүндрэл учруулж, очих бүрт өөр мэргэжилтэн байдаг нь аливаа асуудлыг шийдвэрлэхэд удааших нөхцөл болдог.
- Өсвөр үеийн хүүхдүүдийн оролцоо идэвхи сайн боловч ИС, МСҮТ-ын оюутнууд идэвхи султай оролцдог.

Зөвлөмж

- Цаашид төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулан, БСШУЯ-тай холбогдон Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт өөрсдийн сургалтын хөтөлбөрөөс оруулах санаачлагыг хүргэх.
- Олон талт хамтын ажиллагааг сайжруулах
- ӨЭМТ, ЕБС, Хорооны нийгмийн ажилтнууд болон хэсгийн ахлагч нарыг сургалтанд хамруулсан л бол дараа дараагийн ажлын байр, салбарт орсон ч тэрхүү мэдлэг мэдээллээ түгээх ажлыг үргэлжлүүлэхийг уриалан хамтран эргэх холбоотой ажиллах.

Тайланг бэлтгэсэн:

Б.Оюундарь/ҮЗЗ-ийн зохицуулагч/

Л.Номин-Эрдэнэ /ҮЗЗ-ийн ажлын алба/

Хянасан:

ҮЗЗ-ийн хяналтын хорооны гишүүд